

# 1994 оны мал тооллого

## I. Малчдын тоо, тэдний соёл, ахуйн байдал

**I.1. Малчдын тоо, бүрэлдэхүүн.** 1994 оны жилийн эцсийн мал тооллогоор мал аж ахуйн салбарт нийт 167.3 мянган өрх бүхий 377.1 мянган малчид ажиллаж байна. Малчдын өрхийн тоо өмнөх оныхоос 8.9 хувь буюу 13.7 мянга, малчдын тоо 8.4 хувь буюу 29.2 мянгаар нэмэгдэв.

Нийт малчдын 54.3 хувь нь 16-35 насны залуучууд, 28.2 хувь нь 36-аас тэтгэвэрт гарах хүртлэх насны хүмүүс байна.

Өрх, малчдын тоо, бүрэлдэхүүн

	1991	1992	1993	1994
Малчин өрх (мян)	114.9	143.4	153.6	167.3
Малчдын тоо (мян)	247.5	330.1	347.9	377.1
Үүнээс: 16-35 насны	139.8	174.6	186.8	204.8
36-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	77.1	97.2	96.1	106.3
Тэтгэврийн насны	30.6	58.3	65.0	66.0
Насны бүрэлдэхүүн (хувиар)	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс: 16-35 насны	56.5	52.9	53.7	54.3
36-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	31.1	29.4	27.6	28.2
Тэтгэврийн насны	12.4	17.7	18.7	17.5

Улсын хэмжээгээр 108 мянган ардын аж ахуйтан өрх байгаа нь 1993 оныхоос 34.8 хувь буюу 27.9 мянган өрхөөр нэмэгджээ.

1993 онд нэг малчин өрхөд дунджаар 72 толгой мал ногдож байсан бол 1994 онд 71 толгой мал ногдож байна.  
( Хавсралт хүснэгтийн 1-р хуудаснаас үзнэ үү. Цаашид хавсралт хуудасны дугаарыг заана)

**1.2. Малчдын соёл, ахуйн зарим үзүүлэлт.** Цахилгаан гэрлээр хангагдсан малчин өрх 1993 онд 16.5 мянга байсан бол 1994 онд 19.7 мянга боллоо.

1994 онд нийт малчин өрхийн 11.8 хувь нь цахилгаан гэрэлтэй болсон нь 1993 оныхоос 1.1 пунктээр нэмэгдсэн байна.

Улаанбаатар хот, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн малчин өрхийн 42.5-73.4 хувь, Дорнод; Орхон, Хэнтий, Увс, Дорноговь, Төв аймгийнх 20.6-37.6 хувь нь цахилгаан гэрэлтэй болсон байхад Баян-Өлгий, Өвөрхангай, Хөвсгөл, Архангай аймагт энэ үзүүлэлт дөнгөж 2.5-4.3 хувьтай байна. 1993 онд малчин өрхийн 6.9 хувь буюу 10.6 мянган өрх телевизортэй байсан бол 1994 онд 6.5 хувь буюу 10.9 мянган өрх телевизортэй болов.

Радио хүлээн авагчгүй өрхийн тоо 1994 онд 4.8 мянгаар нэмэгдэж, хангамж нь буурав. Малчин өрхийн 31.8 хувь буюу 53.2 мянга нь радио хүлээн авагчгүй байгаагийн дотор Увс, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Хөвсгөл аймагт малчин өрхийн 40.0-54.6 хувь нь радио нэвтрүүлэг сонсох боломжгүй байна. ( Хавсралт хүснэгт 3 )

1993 онд малчдын өрхийн 0.1 хувь буюу 145 өрх богино долгионы телефон холбоотой байсан бол 1994 онд 0.2 хувь буюу 308 өрх ийм холбоотой болжээ. Орхон аймгийн малчин өрхийн 10.6 хувь, Дорнод, Баянхонгор, Ховд, Сэлэнгэ аймгийн малчдын өрхийн 0.5-1.4 хувь богино долгионы холбоотой байна.

Малчдын өрхийн 73.1 хувь нь гэрийн даавуу бүрээстэй, 66.5 хувь нь брезентэн бүрээстэй байгаа нь өмнөх оныхоос бүрээсний хангамж 6.8-7.0 пунктээр дээшилжээ. Дархан-Уул, Увс, Баян-Өлгий Дорнод, Сэлэнгэ аймагт малчдын гэрийн 42.7-54.9 хувь нь гэрийн брезентэн бүрээсгүй, Өвөрхангай, Увс, Баян-Өлгий, Баянхонгор, Сүхбаатар аймагт 32.7-37.5 хувь нь гэрийн даавуу бүрээсгүй байна.

1994 онд малчин өрхийн 17.8 хувь буюу 29.8 мянган өрх эсгий хийсэн байна. Малчид 1993 онд нийтдээ 191.0 мян.метр гар эсгий хийсэн бол 1994 онд 227.2 мян.метр эсгий хийж ашиглажээ.

Малчин өрхийн соёл, ахуйн хангамжийн зарим үзүүлэлт (мян.өрх)

	1991	1992	1993	1994	1994\1993 хувь	Малчин өрхийн тоонд эзлэх %	
						1993	1994
Цахилгаан гэрэлтэй	12.3	15.5	16.5	19.7	119.3	10.7	11.8
Телевизортэй	4.2	6.9	10.6	10.9	103.4	6.9	6.5
Богино долгион холбоотой өрх	20	30	145	308	212.4	0.1	0.2
Эсгий хийсэн	12.1	25.4	26.2	29.8	114.0	17.0	17.8
Гэрийн даавуу бүрээсгүй	41.4	56.6	52.1	45.1	86.6	33.9	26.9
Гэрийн брезентэн бүрээсгүй	46.4	60.7	61.9	56.1	90.6	40.3	33.5
Радио хүлээн авагчгүй	22.2	39.6	48.4	53.2	109.8	31.5	31.8
Хийсэн эсгий ( мян.метр )	87.9	194.2	191.0	227.2	118.9		

**1.3. Мал аж ахуйн мэргэжилтний хүрэлцээ хангамж.** 1994 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд малын эмч 1715, мал зүйч 379 ажиллаж байгаа нь 1989 онтой зэрэгцүүлбэл мал зүйчийн тоо 68.8 хувь, малын эмчийн тоо 6.1 хувь буурсан байна. Харин малын эмчийн тоо 1993 оныхоос 47-оор нэмэгджээ.

Мал аж ахуйн мэргэжилтний тоо, хангамж (мян)

	1989	1992	1993	1994	1994\1989%
Мал зүйч	1214	501	485	379	78.1
Малын эмч	1827	1661	1668	1715	102.8
Нэг мал зүйчид ногдох малын тоо ( мян.тол )	20.3	51.3	51.9	70.7	136.2
Нэг малын эмчид ногдох малын тоо ( мян.тол )	13.5	15.5	15.1	15.6	103.3

1989 онд улсын хэмжээгээр нэг мал зүйчид дунджаар 20.3 мян.мал ногдож байсан бол 1994 онд 70.7 мян.мал ногдох болов.

Одоо Өвөрхангай, Дархан-Уул, Ховд, Завхан, Өмнөговь, Дундговь аймагт нэг мал зүйчид дунджаар 102-147 мян.толгой мал ногдож байна.  
( Хавсралт хуудасны дугаар 4 )

## II. МАЛЫН ТОО

**2.1. Нийт малын тоо.** 1994 оны эцэст 26.8 сая мал тоологдсон нь 1993 оныхоос толгойн дүнгээр 1633.4 өссөний дотор ямаа 1134.3 мянга, үхэр 274.7, адуу 218.5, хонь 7.4 мянгаар нэмэгдэж, харин тэмээ 1.5 мянгаар цөөрөв. Бодод шилжүүлснээр малын тоо 1993 оныхоос 634.0 мянгаар өссөн байна.

Малын тоо ( мян.тол)

	1991	1992	1993	1994	1994/1993	
					%	Зөрүү
<b>Бодоор *</b>	<b>8905.0</b>	<b>8785.3</b>	<b>8532.2</b>	<b>9166.2</b>	<b>107.7</b>	<b>634.0</b>
<b>Толгойн тоо</b>	<b>25527.9</b>	<b>25694.1</b>	<b>25174.7</b>	<b>26808.1</b>	<b>106.5</b>	<b>1633.4</b>
Тэмээ	476.0	415.2	367.7	366.1	99.6	-1.5
Адуу	2259.3	2200.2	2190.3	2408.9	110.0	218.5
Үхэр	2822.0	2819.2	2730.5	3005.2	110.1	274.7
Хонь	14721.0	14657.0	13779.2	13786.6	100.1	7.4
Ямаа	5249.6	5602.5	6107.0	7241.3	118.6	1134.3

\* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг нэг бод, тэмээг 1.5 бод, 6 хонь, 8 ямааг тус бүр нэг бод гэж тооцов.

.....

Бодод шилжүүлснээр Дорнодоос бусад, толгойн тоогоор Дорнод, Хэнтий Сүхбаатар, Говьсүмбэрээс бусад аймаг, Улаанбаатар хот малынхаа тоог 1993 оныхоос өсгөсний дотор Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн малын тоо өнгөрсөн оныхоос бодод шилжүүлснээр 43.7-88.1 мянга, толгойн дүнгээр 151.2-281.7 мянгаар нэмэгдсэн байна. Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Говь-Алтай, Өмнөговь аймаг малаа таван төрөл дээр нь өсгөв. ( Хавсралт хүснэгт 12 )

Сумдаас Сэлэнгийн Сайхан, Булганы Хангал, Говь-Алтайн Чандмань, Баянхонгорын Баянбулаг, Баянговь зэрэг 14 аймгийн 111 сум малаа таван төрөл бүр дээр нь өсгөжээ.

Харин Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Говьсүмбэр аймгийн мал урьд оныхоос 7.5-79.4 мянгаар хорогджээ. Сумын дотроос малынхаа тоог урьд оныхоос 19.3-32.4 хувь буюу 4.9-35.4 мянгаар хорогдуулсан Дорнодын Халхгол, Гурванзагал, Хэнтийн Галшар, Баян-Овоо, Төв аймгийн Баян сумд сүүлийн байранд орж байна.

Малын өсөлт, бууралтын хэмжээгээр аймгуудыг байр эзлүүлбэл :

	1994 \ 1993			
	Бодод шилжүүлснээр		Толгойн тоогоор	
	хувь	мян.бод	хувь	мян.тол
<b>Малаа илүүтэй өсгөсөн</b>				
1.Баян-Өлгий	115.3	-	115.0	151.2
2.Баянхонгор	114.7	-	116.4	281.7
3.Завхан	114.5	-	112.1	243.0
4.Өвөрхангай	112.6	-	111.4	240.2
5.Говь-Алтай	111.2	-	111.7	206.4
<b>Малаа хорогдуулсан</b>				
1.Дорнод	95.4	-	91.2	-62.4
2.Хэнтий	100.2	-	93.3	-79.4
3.Сүхбаатар	100.3	-	95.9	-46.3
4.Говьсүмбэр	100.4	-	92.9	-7.5

Малын тоо 1990 оноос эхлэн 25 саяаас давж, 1994 онд 27 саяд дөхөж очсон нь сүүлийн 34 жилд хүрээгүй амжилт юм. Малын тоо толгойн сүүлийн 4 жилийн дунджийг өмнөх 30 жилийн ( 1961 – 1990 он ) дундажтай зэрэгцүүлэхэд тэмээнээс бусад төрлийн мал өссөн хандлагатай байна.

Малын тоо толгойн 1961-1990 оны 30 жилийн дунджийг сүүлийн дөрвөн жилийн дундажтай зэрэгцүүлэн үзүүлвэл : ( сая.толгой )

	1961 – 1990	1991 – 1994
Бүгд	23.1	25.8
Тэмээ	0.62	0.41
Адуу	2.2	2.3
Үхэр	2.3	2.8
Хонь	13.5	14.2
Ямаа	4.5	6.1

1990 оноос хойш сүүлийн гурван жилд ямаанаас бусад төрлийн малын тоо толгой жил дараалан хорогдож байсан үзэгдэл 1994 оноос эхлэн багассаар, 1995 онд хонины тоо ноднингийн түвшнээс ялимгүй давж, адуу сүүлийн 28 жилд, үхэр урьд нь статистикийн тоо баримтанд хэзээ ч тэмдэглэгдэж байгаагүй тоо ( 3 сая )-нд хүрлээ.

Малын, тоо толгойн хүрсэн дээд хэмжээг үзүүлбэл:

	1918 оноос хойш		Жилийн эцэст тоолдог болсон 1961 оноос хойш	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	27535.7	1941	26808.1	1994
Тэмээ	895.3	1954	751.7	1961
Адуу	2579.4	1941	2432.6	1965
Үхэр	3005.2	1994	3005.2	1994
Хонь	15936.4	1941	15083.0	1990
Ямаа	7241.3	1994	7241.3	1994

Тэмээг хамгаалах талаар авч байгаа арга хэмжээ 1994 онд үр дүнгээ өгч урьд оныхтой харьцуулбал 100эхээс бойжуулах ботго 5-аар нэмэгдэж, тэмээний зүй бус хорогдол 14.3 мянга, зах, зээл, хүнсний хэрэглээний зарлага 30.6 мянгаар багасч, тэмээн сүрэг ноднингийнхоо хэмжээнд хүрэхэд 1.5 мянгаар дутсан нь тэмээний тоог одоогийн түвшинд нь тогтвортой барьж, цаашид өсгөх найдвар байгааг харуулж байна.

1990 оноос хойш сүүлийн дөрвөн жилд сүрэгт тэмээ, хонины эзлэх хувийн жин мэдэгдэхүйц буурч ирлээ.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	1990	1991	1992	1993	1994
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Тэмээ	2.1	1.9	1.6	1.5	1.4
Адуу	8.8	8.8	8.6	8.7	9.0
Үхэр	11.0	11.0	11.0	10.8	11.2
Хонь	58.3	57.7	57.0	54.7	51.4
Ямаа	19.8	20.6	21.8	24.3	27.0

Мал нь хорогдсон зүүн гурван аймагт өнгөрсөн онд төл харьцангуй муу бойжуулсны зэрэгцээ хүнсэнд зориулан зах зээлд малын борлуулалт ихэссэн нь малын тоо буурахад нөлөөлжээ.

Улсын дунджаар оны эхний малын 25.0 хувьтай тэнцэх хэмжээний малыг хүнсэнд хэрэглэсэн байхад дээрх аймгуудад энэ үзүүлэлт 30.0- 32.2 хувьд хүрсэн байна.

Улсад нийт малын тоогоор болон адуугаар Өвөрхангай, хониор Завхан, үхрээр Хөвсгөл, ямаагаар Баянхонгор, тэмээгээр Өмнөговь аймаг тэргүүн байранд байна. Хамгийн олон малтай сумын тоонд Дундговь аймгийн Эрдэнэдалай сум нийт малын тоогоор ( 251.4 мян ) болон хонь ( 138.2 ), адуугаар ( 25.4 мян ),

Өмнөговийн Ханбогд сум тэмээгээр ( 12.7 мян ), Өвөрхангайн Уянга сум үхрээр ( 35.1 мян ), Богд сум ямаагаар ( 120.8 мян ) тус тус орж байна.

**Хувийн ( амины ) малын тоо.** 1994 онд улсын хэмжээгээр аминдаа малтай 289.2 мянган өрх тоологдсоны дотор 57.8 хувь буюу 167.3 мянга нь малчин өрх , 42.2 хувь буюу 121.9 мянга нь мал бүхий бусад иргэдийн өрх байна.

Сүүлийн жилүүдэд нийгмийн малыг хувьчилснаар хувийн малын тоо 1990 онд нийт малын 31.9 хувь байснаа 1991 онд 54.9, 1992 онд 70.4, 1993 онд 89.6, 1994 онд 91.5 хувийг эзлэх болов. 1994 онд хувийн малын тоо 24.5 саяд хүрч, 1993 оныхоос 1962.1 мянгаар нэмэгдлээ. Ямаа, адуу, тэмээ, үхрийн 93.6 – 96.1, хонины 88.0 хувь нь хувийн аж ахуйд ногдох болжээ.

Дорнод, Хэнтийгээс бусад бүх аймаг, хотод хувийн малын тоо урьд оныхоос 1.2 – 17.3 хувиар өссөний дотор Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Говь-Алтай аймагт 227.6 – 280.2 мянга, Баян-Өлгий, Өмнөговь, Хөвсгөл, Архангай, Ховд аймагт 106.0 – 151.2 мянгаар нэмэгдэв.

Хувийн малын өсөлт ( мян.тол )

	Толгойн тоо			1994\1993	
	1993	1994	-	Хувь	зөрүү
Архангай	1436.6	1570.2	-	109.3	133.7
Баян-Өлгий	975.5	1126.8	-	115.5	151.2
Баянхонгор	1623.6	1903.8	-	117.3	280.2
Булган	901.3	953.5	-	105.8	52.2
Говь-Алтай	1687.0	1911.5	-	113.3	224.5
Дорноговь	660.1	711.3	-	107.8	51.2
Дорнод	533.8	503.3	-	94.3	-30.5
Дундговь	1429.2	1470.5	-	102.9	41.2
Завхан	1920.8	2176.3	-	113.3	255.4
Өвөрхангай	1997.6	2225.2	-	111.4	227.6
Өмнөговь	857.8	1001.0	-	116.7	143.2
Сүхбаатар	884.1	895.0	-	101.2	11.0
Сэлэнгэ	255.4	298.5	-	116.8	43.0
Төв	1231.4	1278.7		103.8	47.3
Увс	1509.7	1601.8	-	106.1	92.1
Ховд	1665.6	1771.6	-	106.4	106.0
Хөвсгөл	1576.6	1715.4	-	108.8	138.8
Хэнтий	1009.4	952.5	-	94.4	-57.0
Дархан-Уул	87.8	101.0	-	115.1	13.2
Улаанбаатар	206.9	229.5	-	110.9	22.6
Орхон	71.5	81.3	-	113.7	9.8
Говьсүмбэр	43.5	48.7	-	111.9	5.2
ДҮН	22565.2	24527.2	-	108.7	1962.1

Хувийн малын 50.2 хувь нь ардын аж ахуйтанд, 29.7 хувь нь ХАА-н компани, хоршооны гишүүдэд, 20.1 хувь нь ХЭАА, бусад иргэдэд ногдож байна.

Хувийн аж ахуйд байгаа малын бүтцийг авч үзвэл хонь 49.5 хувь, ямаа 28.4, үхэр 11.4, адуу 9.3, тэмээ 1.4 хувийг эзлэж байна.

Хувийн мал аж ахуйн мал, төрлөөр ( мян.тол )

	Малтай өрхийн тоо	Бүгд	Ү ү н э э с				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
1990	262.3	<b>8242.9</b>	88.2	1108.1	1457.5	3684.7	1904.4
1991	288.9	<b>14002.6</b>	186.3	1492.1	1896.6	7209.4	3218.2
1992	301.5	<b>18081.1</b>	253.7	1728.0	2237.4	9589.1	4272.9
1993	289.7	<b>22565.2</b>	335.0	2026.8	2503.5	11902.0	5797.9
1994	289.2	<b>24527.2</b>	343.3	2279.0	2811.8	12133.8	6959.3

1994 онд тоологдсон хувийн аж ахуйн мал ( мян )

	Өрхийн тоо	Малын тоо бүгд	Ү ү н э э с				
			тэмээ	адуу	үхэр	Хонь	ямаа
ХАА-н компани, хоршооны гишүүд	67.2	<b>7289.7</b>	104.6	718.6	820.6	3622.7	2023.2
Ардын аж ахуйтан	108.0	<b>12300.2</b>	204.3	1147.1	1289.8	6076.2	3582.8
ХЭАА,бусад Иргэд	114.0	<b>4936.7</b>	34.4	413.1	703.2	2434.8	1353.2
Алдуул мал	-	<b>0.6</b>	0.0	0.2	0.2	0.1	0.1
Дүн	289.2	<b>24527.2</b>	343.3	2279.0	2811.8	12133.8	6959.3

Одоо дунджаар ардын аж ахуйтан нэг өрхөд 114 толгой мал, хөдөө аж ахуйн компани, хоршооны гишүүн өрхөд 108, мал бүхий бусад иргэдийн нэг өрхөд 43 толгой мал ногдож байна.

Иргэдийн амины малын бүлэглэлтээс үзвэл 51-100 малтангууд бусад бүлгээс харьцангуй олонхи нь болж байна. 1994 онд 201-500 малтай аж ахуйтны тоо илүүтэй олширчээ. 1994 онд хувийн малтай нийт өрхөд 10 хүртэл малтай өрхийн эзлэх хувийн жин 1993 оныхоос 0.5 пунктээр багасч, 101-200 толгой малтай өрхийн хувийн жин 0.7, 201-500 малтайнх 1.3, 501 –ээс дээш малтайнх 0.3 пунктээр нэмэгдсэний дотор 501-1000 малтай өрх 2123, 1001-ээс дээш малтай өрх 144 байна. Бүлэглэлтээс үзэхэд 100 хүртлэх малтай өрхүүдийн тоо төдийлөн өсөөгүй байхад 100-аас дээшхи малтай өрхүүдийн малын тоо илүү хурдан өссөн хандлага ажиглагдаж байна.

Иргэдийн хувийн малын бүлэглэлт ( тоо-мян )

	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо ( мян.тол )	
	1993	1994	1993	1994	1993	1994
10 хүртэл малтай	48.3	43.7	16.7	16.2	288.0	295.6
11-30 малтай	57.0	50.6	19.7	18.6	1161.3	1098.4
31-50 малтай	43.7	40.2	15.1	14.5	1769.4	1711.8
51-100 малтай	63.4	61.1	21.9	21.8	4593.1	4613.9
101-200 малтай	51.4	53.5	17.7	18.4	7123.6	7480.3
201-500 малтай	24.6	31.4	8.5	9.8	6832.2	7865.5
501-1000 малтай	1.3	3.1	0.4	0.7	744.2	1297.3
1001-1500 малтай	0.05	0.3	-	-	53.0	163.8
1501-2000 малтай	-	0.017	-	-	-	-
2001-с дээш мал	-	0.007	-	-	-	-

Улсын дунджаар малтай нэг өрхөд 29 бод, 85 толгой мал ногдож байхад Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай аймагт 39-45 бод, Дундговь, Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Баянхонгор, Дорноговь, Завхан аймагт 114-154 толгой мал ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох хувийн малын тоо

	Бодод шилжүүлснээр : Толгойн тоогоор					
	1993	1994	-	1993	1994	-
Архангай	28.3	30.7	-	66	71	-
Баян-Өлгий	21.0	22.9	-	74	80	-
Баянхонгор	28.3	32.5	-	98	115	-
Булган	30.7	32.8	-	73	75	-
Говь-Алтай	33.2	38.5	-	131	154	-
Дорноговь	36.6	43.3	-	99	117	-
Дорнод	22.9	24.2	-	51	51	-
Дундговь	42.7	44.8	-	141	146	-
Завхан	31.4	35.8	-	102	114	-
Өвөрхангай	27.7	31.2	-	84	94	-
Өмнөговь	38.2	41.9	-	108	124	-
Сүхбаатар	34.1	34.9	-	87	85	-
Сэлэнгэ	9.2	10.3	-	21	24	-
Төв	23.3	25.8	-	60	65	-
Увс	25.1	26.6	-	80	84	-
Ховд	32.7	34.6	-	115	119	-
Хөвсгөл	27.8	30.4	-	68	73	-
Хэнтий	31.4	31.9	-	78	74	-
Дархан-Уул	6.9	8.4	-	17	20	-
Улаанбаатар	6.9	8.2	-	17	20	-
Орхон	8.1	10.4	-	19	26	-
Говьсүмбэр	13.7	16.4	-	36	41	-
ДҮН	26.7	29.4	-	78	85	-



**Хээлтэгч мал.** 1994 оны эцэст 11513.4 мянган хээлтэгч мал тоологдсон нь урьд оныхоос 433.7 мянгаар өссөний дотор эм ямаа 391.2 мянга, гүү 70.1 мянга, үнээ 127.6 мянга, ингэ 1.6 мянгаар өсч, эм хонь 156.8 мянгаар буурсан байна.

Хээлтэгч малын тоо (мян.тол)

	1991	1992	1993	1994	1994\1993	
					Хувь	Зөрүү
Ингэ	127.3	112.2	99.2	100.8	101.6	1.6
Гүү	575.6	566.0	580.2	650.3	112.1	70.1
Үнээ	1064.0	1032.2	1043.0	1170.6	112.2	127.6
Эм хонь	7407.2	7098.8	6476.9	6320.1	97.6	-156.8
Эм ямаа	2466.3	2653.9	2880.4	3271.5	113.6	391.2
<b>ДҮН</b>	<b>11640.4</b>	<b>11463.1</b>	<b>11079.7</b>	<b>11513.3</b>	<b>103.9</b>	<b>433.7</b>

Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг хээлтэгч малынхаа тоог урьд оныхоос 20.4 – 36.4 мянга, Дорноговь, Говьсүмбэр аймаг 2.2-8.1 мянгаар хорогдуулжээ. (Хавсралт хуудасны дугаар 25)

Бүх хээлтэгч малын 90.0 хувь нь хувийн, 10 хувь нь аж ахуйн бусад хэвшилд хамрагдаж байгаагийн дотор ингэний 92.9, гүүний 94.4, үнээний 92.3, эм хонины 86.1, эм ямааны 95.7 хувь хувийн аж ахуйд байна.

1994 онд 1827.5 мян.хээлтэгч шинээр нас дэвшиж нэмэгдсэн нь нийт хээлтэгчийн 15.9 хувь болж байна.

Хээлтэгч малын тоо 12 сая толгойд хүрсэн 1990 оны хэмжээнд хүрээгүй байна.

1961 оноос хойш олон хээлтэгч мал тоологдсон жил

	мян.тол	Он		Мян.тол	Он
Ингэ	226.9	1961	Эм хонь	7786.1	1990
Гүү	654.2	1967	Эм ямаа	3271.5	1994
Үнээ	1170.6	1994			

**Төл бойжилт.** 1994 онд гарсан төлийн 94.1 хувь буюу 8.6 сая төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 868.2 мянгаар нэмэгджээ. Бойжуулсан нийт төлөөс 72.1 мянгыг аж ахуйн дотоод хэрэгцээнд, 9.0 мянгыг каракуль арьсанд нядалжээ. (Хавсралт хуудасны дугаар 27)

Төл бойжилт ( мян.тол )

	Бүгд	Ү Ү Н Э Э С					Зөрүү
		ботго	унага	тугал	хурга	ишиг	
Гарсан	9170.2	39.2	401.5	831.2	5421.9	2476.4	270.8
Бойжсон	8630.0	36.7	387.6	812.9	5085.2	2307.6	868.2
Хорогдсон	540.2	2.5	13.9	18.3	336.7	168.8	-597.4
Бойжилтын Хувь	94.1	93.5	96.6	97.8	93.8	93.2	6.9

1994 онд хамгийн олон унага, тугал, ишиг бойжуулан авав.

Бойжуулсан төл ( мян.тол )

	1986-1990 оны дундаж	1991	1992	1993	1994
Ботго	60.3	52.9	44.7	36.6	36.7
Унага	324.2	343.8	314.9	289.8	387.6
Тугал	711.9	762.5	725.2	669.3	812.9
Хурга	6152.8	6468.8	5726.8	4906.6	5085.2
Ишиг	1772.7	1983.7	1924.7	1860.5	2307.6
<b>Бүгд</b>	<b>9021.9</b>	<b>9611.7</b>	<b>8736.3</b>	<b>7762.8</b>	<b>8630.0</b>

1961 оноос хойших хугацаанд хамгийн олон төл бойжуулсан жил

	Мян.төл	он		мян.төл	он
<b>Бүгд</b>	<b>9673.3</b>	<b>1989</b>	Тугал	812.9	1994
Ботго	74.4	1975	Хурга	6569.6	1989
Унага	387.6	1994	Ишиг	2307.6	1994

1994 онд 100 эхээс бойжуулсан төл өмнөх таван жилийн ( 1986-1990 ) дунджаас 3-аар бага байгааг төлийн төрлөөр авч үзвэл дунджаас тугал 9, унага 5-аар их, хурга 7, ботго 3-аар бага, ишиг дунжийн түвшинд бойжсон байна.

100 эхээс бойжуулсан төл

	1986-1990 оны дундаж	1990	1991	1992	1993	1994
Ботго	40	38	38	35	32	37
Унага	62	61	61	55	51	67
Тугал	69	70	68	68	65	78
Хурга	86	88	83	77	69	79
Ишиг	80	82	82	78	70	80
<b>Бүгд</b>	<b>81</b>	<b>83</b>	<b>80</b>	<b>75</b>	<b>68</b>	<b>78</b>

100 хээлтэгчээс Баян-Өлгий, Завхан аймаг 91-92, Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Хөвсгөл, Сэлэнгэ, Увс аймаг 80-88 төл бойжуулсан байхад Улаанбаатар хот, Дархан-Уул, Төв, Орхон, Говьсүмбэр

аймаг 52-64, Дорнод, Дорноговь, Хэнтий аймаг 65-67 төл бойжуулжээ.  
( Хавсралт хүснэгт 28, 29 )

Хувийн малын 100 эх малаас бойжуулсан төл мал аж ахуйн бусад хэвшлийнхээс 24-өөр, үүний дотор ботго 21, унага 37, тугал 38, хурга 22, ишиг 30-ээр илүү байна.

Хувийн аж ахуйн 100 эхээс  
бойжуулсан төл

	1991	1992	1993	1994
Ботго	51	49	42	39
Унага	76	68	60	70
Тугал	85	86	78	82
Хурга	96	93	86	82
Ишиг	87	88	82	82
<b>Бүгд</b>	<b>90</b>	<b>89</b>	<b>82</b>	<b>81</b>

**Том малын зүй бус хорогдол.** 1994 оны эхний малын 2.7 хувь буюу 690.0 мянган том мал зүй бусаар хорогдсон нь 1993 оныхоос 962.1 мянга, 1986-1990 оны дунджаас 61.9 мянгаар багассан байна.

Том малын зүй бус хорогдол ( мян.тол )

	1986- 1990оны дундаж	1991	1992	1993	1994
Тэмээ	25.8	20.8	21.4	23.8	9.5
Адуу	64.3	72.7	80.6	140.4	41.6
Үхэр	79.5	104.6	118.1	278.9	78.3
Хонь	438.7	624.1	516.6	927.9	423.8
Ямаа	143.6	156.0	134.3	281.1	136.8
<b>Бүгд</b>	<b>751.9</b>	<b>978.2</b>	<b>871.0</b>	<b>1652.1</b>	<b>690.0</b>

Оны эхний малд зүй бус хорогдолын эзлэх хувь

	1986- 1990оны дундаж	1991	1992	1993	1994
Тэмээ	4.7	3.9	4.5	5.7	2.6
Адуу	3.1	3.2	3.6	6.4	1.9
Үхэр	3.1	3.7	4.2	9.9	2.9
Хонь	3.3	4.1	3.5	6.3	3.1
Ямаа	3.2	3.0	2.6	5.0	2.2
<b>Бүгд</b>	<b>3.3</b>	<b>3.8</b>	<b>3.4</b>	<b>6.4</b>	<b>2.7</b>

Сүхбаатар, Хэнтий, Дундговь, Төв, Говьсүмбэр аймагт оны эхний малын 5.0-14.4 хувь буюу нийтдээ 297.5 мянган том мал зүй бусаар хорогдсон нь

улсын хэмжээний нийт хорогдлын 43.1 хувийг эзлэж байна. ( Хавсралт хуудасны дугаар 31 )

Том малын зүй бус хорогдолын 37.2 хувь буюу 256.8 мянга нь өвчнөөр, 10 хувь буюу 69 мянга нь гэнэтийн аюулаар хорогдов. Хорогдсон нийт малын 72.4 хувь нь хувийн мал байна. Хувийн малын 2.2 хувь, аж ахуйн бусад хэвшлийн малын 7.3 хувь хорогдов.

1961 оноос хойш малын зүй бус хорогдол хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага хорогдол гарсан		Хамгийн их хорогдол гарсан	
	мян.тол	ОН	мян.тол	ОН
<b>Бүгд</b>	<b>510.3</b>	<b>1989</b>	<b>2663.8</b>	<b>1968</b>
Тэмээ	9.5	1994	66.3	1966
Адуу	41.6	1994	235.3	1968
Үхэр	52.3	1974	278.9	1993
Хонь	293.2	1989	1606.3	1968
Ямаа	89.3	1989	574.8	1968

**Малын хээл хаялт, сувайралт.** 1994 оны эхний хээлтэгч малын 12.3 хувь буюу 1359.7 мянга нь хээл хаяж, сувайрсан нь 1993 оныхоос 33.2 хувь буюу 410.4 мянгаар цөөрөв.

Улаанбаатар хот, Дархан-Уул, Дорнод, Дундговь аймаг оны эхний хээлтэгч малынхаа 19.5-19.8, Төв, Орхон аймаг 18.1-18.5 хувиас дээрхи шалтгаанаар төл авч чадсангүй. Дундговь аймагт гүүний 44.8 хувь, үнээний 24.2 хувь, эм ямааны 23.5 хувь сувайрч, хээл хаясан нь бусдаас харьцангуй их хэмжээтэй байна.( Хавсралтын хуудасны дугаар 32- 34 )

Мал хээл хаях, сувайрах шалтгааны зонхилох нөлөөллөөр Улаанбаатар хот, Төв, Дархан-Уул, Дорнод, Орхон, Говьсүмбэр аймаг 1994 онд 100 эхээс хамгийн цөөхөн төл бойжуулсан нь улсын дунджаас 13-26 толгойгоор бага байна.

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо ( мян.тол )

	Төл өгөөгүй хээлтэгч мал бүгд				үүнээс сувайрсан			
	1986-1990 дундаж	1993	1994	1994\1986-90 хувь	1986-1990 дундаж	1993	1994	1994\1986-1990 хувь
Ингэ	12.5	16.1	11.3	90.4	9.9	13.0	9.5	96.0
Гүү	180.1	203.0	154.4	85.7	158.1	149.9	121.3	76.7
Үнээ	278.1	248.8	183.4	65.9	240.8	194.3	148.9	61.8
Эм хонь	446.3	913.0	669.8	150.1	276.0	625.9	483.4	175.2
Эм ямаа	275.6	389.2	340.8	123.7	139.7	226.8	204.6	146.5
<b>ДҮН</b>	<b>1192.6</b>	<b>1770.1</b>	<b>1359.7</b>	<b>114.0</b>	<b>824.5</b>	<b>1209.9</b>	<b>967.7</b>	<b>117.4</b>

Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь

	Бүгд			үүнээс сувайрсан		
	1986-1990 о\д	1993	1994	1986-1990	1993	1994
Ингэ	8.2	14.4	11.4	6.5	11.6	9.5
Гүү	34.4	35.9	26.6	30.2	26.5	20.9
Үнээ	26.9	24.1	17.6	23.3	18.8	14.3
Эм хонь	6.2	12.9	10.3	3.8	8.8	7.5
Эм ямаа	12.5	14.7	11.8	6.3	8.5	7.1
<b>ДҮН</b>	<b>10.8</b>	<b>15.4</b>	<b>12.3</b>	<b>7.4</b>	<b>10.6</b>	<b>8.7</b>

1961 оноос хойш эх малын хээл хаялт, сувайралт хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага		Хамгийн их	
	мян.тол	он	мян.тол	Он
Бүгд	645.8	1963	1907.9	1977
Ингэ	9.7	1989	26.4	1973
Гүү	159.5	1962	333.6	1973
Үнээ	106.1	1962	326.0	1981
Эм хонь	190.6	1962	913.0	1993
Эм ямаа	124.7	1963	558.1	1968

**Хээлтээгч, хээлтүүлэгчийн тохироо.** Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдаж, үйлдвэрлэлд ажиллаж байгаа мал зүйчийн тоо цөөрч, мал нийлүүлэгийн ажилд тавих анхаарал суларсанаас малын хээл хаялт, сувайралт 1986 – 1990 оны дунджаас төдийлөн буурахгүй, ялангуяа бог малын сувайралт нэмэгдэх хандлагатай байна.

Мал аж ахуйд ажиллаж байгаа мал зүйчийн тоо 1990 онд 956 байсан бол 1994 онд 379 болжээ. 1990 онд улсын хэмжээгээр дунджаар нэг мал зүйчид 27 мянган мал ногдож байсан бол 1994 онд 71 мянган мал ногдох боллоо. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад одоо улсын дунджаар 63 эм хонь, 59 эм ямаа, ялангуяа хувийн аж ахуйд 68 эм хонь, 60 эм ямаа ногдож, хуц, ухна нэн дутагдалтай байна.

Хээлтүүлэгч малын тоо ( мян.тол )

	Бүгд				үүнээс шинээр тавьсан			
	1992	1993	1994	1994\1993	1992	1993	1994	1994\1993
Буур	4.0	4.2	4.7	111.9	49	60	62	103.3
Азрага	81.3	85.4	92.9	108.8	0.6	0.6	0.7	116.7
Бух	60.4	55.0	57.0	103.6	0.9	0.6	1.0	166.7
Хуц	143.8	100.3	100.4	100.1	1.9	0.9	2.5	277.8
Ухна	54.5	48.2	55.9	116.0	0.5	0.4	1.1	275.0
<b>ДҮН</b>	<b>344.0</b>	<b>293.1</b>	<b>310.9</b>	<b>106.1</b>	<b>3.9</b>	<b>2.6</b>	<b>5.4</b>	<b>207.7</b>

Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгч малын тоо

	Үржлийн норм			Хувийн		Бусад хэвшлийн	
		1993	1994	1993	: 1994	1993	: 1994
Ингэ	20-25	23	22	23	22	24	23
Гүү	12-15	7	7	7	7	10	11
Үнээ	35-45	21	21	21	21	18	17
Эм хонь	25-30	65	63	76	68	35	44
Эм ямаа	25-30	60	59	64	60	28	38

1990 онд нийт 20.9 мянган хурган хуц, 7.5 мянган ухна ишиг нэмж тавж байсан бол 1994 онд 2.5 мянган хурган хуц, 1.1 мянган ухна ишиг тавьсан байна. Говь-Алтай, Төв, Архангай, Орхон, Завхан, Булган аймагт хуц, Говь-Алтай, Ховд, Баянхонгор аймагт ухна бусдаас илүү дутагдалтай болжээ.  
( Хавсралт хуудасны дугаар 26 )

**Малын хэрэглээний зарлага.** Оны эхны нийт малын 25.0 хувьтай тэнцэх 6297.6 мянган малыг хүнсний хэрэгцээнд зарцуулжээ. Оны эхний тэмээний 7.8 хувьтай тэнцэх тооны тэмээг хүнсэнд хэрэглэсэн нь 1986 – 1990 оны хүнсний хэрэглээний дундаж хэмжээнд ойртож, тэмээний тоо толгой тогтворжиход нөлөөлөв.

Харин ямааны 31 – 33 хувийг хүнсэнд хэргэлдэг байсан бол 1993 онд 19 хувь, 1994 онд 17 хувь болсноор тоо толгой нь эрс өсөх боломж бүрджээ. ( Хавсралт хуудасны дугаар 30 )

Малын нийт хэрэглээний зарлага. ( мян.тол )

	1986-1990 оны дундаж	1991	1992	1993	1994
<b>Бүгд</b>	<b>7559.8</b>	<b>8930.5</b>	<b>7683.5</b>	<b>6617.8</b>	<b>6297.6</b>
Тэмээ	38.9	93.6	84.1	59.3	28.6
Адуу	201.7	273.8	293.4	159.4	127.5
Үхэр	544.3	684.6	609.9	479.1	459.9
Хонь	5311.3	6174.6	5258.6	4845.2	4645.0
Ямаа	1463.6	1703.9	1437.5	1074.8	1036.6

Оны эхний малд эзлэх хувь

	1986-1990 оны дундаж	1991	1992	1993	1994
<b>Бүгд</b>	<b>31.8</b>	<b>34.5</b>	<b>30.1</b>	<b>25.8</b>	<b>25.0</b>
Тэмээ	7.1	17.4	17.7	14.3	7.8
Адуу	9.5	12.1	13.0	7.2	5.8
Үхэр	20.8	24.0	21.6	17.0	16.8
Хонь	38.4	40.9	35.7	33.1	33.7
Ямаа	31.3	33.2	27.4	19.2	17.0

**Сүргийн бүтэц.** Нийт сүргийн 34.6 хувь нь төл, өсвөр насны, 42.9 хувь нь хээлтэгч, 21.3 хувь нь ажлын болон эр сувай мал, 1.2 хувь нь хээлтүүлэгч мал байна.

Сүргийн бүтэц ( хувиар )

	Төл, өсвөр насны		Ажлын ба эр сувай		Хээлтэгч		Хээлтүүлэгч		Бүгд
	1993	1994	1993	1994	1993	1994	1993	1994	
<b>ДҮН</b>	<b>33.3</b>	<b>34.6</b>	<b>21.5</b>	<b>21.3</b>	<b>44.0</b>	<b>42.9</b>	<b>1.2</b>	<b>1.2</b>	<b>100.0</b>
Тэмээ	31.2	29.1	40.7	42.1	27.0	27.5	1.2	1.3	100.0
Адуу	33.1	33.6	36.5	35.5	26.5	27.0	3.9	3.9	100.0
Үхэр	44.7	45.4	15.1	13.8	38.2	39.0	2.0	1.9	100.0
Хонь	32.7	34.4	19.6	19.1	47.0	45.8	0.7	0.7	100.0
Ямаа	29.9	31.0	22.1	23.1	47.2	45.2	0.8	0.8	100.0

Бойжуулсан төлийн тоо нэмэгдсэнээр тэмээнээс бусад төрлийн малын сүргийн бүтцэд төл, өсвөр насны малын эзлэх хувийн жин өсөв. Нийт сүрэгт хээлтэгч малын эзлэх хувийн жин 42.9 болж, урьд оныхоос 1.1 пунктээр буурсны дотор эм ямаа 2.0, эм хонь 1.2-оор буурч, ингэ, үнээ, гүүний хувийн жин 0.5- 0.8 пунктээр нэмэгдэв. ( Хавсралт хуудасны дугаар 16 – 21 )

Сүргийн бүтэц, өмчийн хэлбэрээр ( хувиар )

	хувийн			өмчийн бусад хэвшлийн		
	1992	1993	1994	1992	1993	1994
Төл, өсвөр насны	37.8	34.3	35.3	30.4	25.0	26.5
Ажлын ба эр сувай	19.9	21.4	21.3	14.8	22.0	21.6
Хээлтэгч	41.2	43.2	42.2	52.0	51.2	50.5
Хээлтүүлэгч	1.0	1.1	1.1	2.0	1.8	1.4
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

1994 оны эцэст ажлын ба эр сувай 5720.5 мянган эр мал тоологдсон нь өмнөх оныхоос 308.0 мянгаар нэмэгдсэний дотор эр ямаа 317.7 мянга, адуу 56.7 мянга, тэмээ 4.4 мянга, үхэр 1.5 мянгаар өсч, эр хонь 72.3 мянгаар буурлаа.

Ажлын мал. 1994 онд ажил эдэлгээний 138.7 мян.ат, 694.7 мян.морь, 101.1 мян.шар байгаа нь өмнөх оныхоос ат 7.7 мянга, морь 40.8 мянга, шар 20.9 мянгаар нэмэгджээ. Улсын хэмжээгээр атны 90.1, морины 81.2, шарны 24.4 хувийг ердийн хөсөгт ашиглаж байгаа нь өнгөрсөн оныхоос атны ашиглалт 2.5, шарных 4.9 пунктээр өссөн байна.

Баянхонгор, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Говь-Алтай аймагт нийт атныхаа 93-100 хувь, Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Булган аймагт нийт шарны 30-51 хувийг ашиглаж байна. ( Хавсралт хүснэгт 35 )

**II.2. Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.**

**Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.** 1994 оны эцэст цэвэр үүлдрийн 338.6 мянга, эрлийз 583.0 мянга, нутгийн шилдэг омгийн 846.1

мянган мал тоологдсон нь 1993 оныхоос цэвэр үүлдрийн мал 3.8 мянга, нутгын шилдэг омгийн мал 21.4 мянгаар өсч, эрлийз мал 83.6 мянгаар цөөрсөн байна.

Цэвэр үүлдрийн болон эрлийз малын тооны өсөлт, бууралт аль аймагт ямар хэмжээтэй байгааг хавсралт хүснэгтийн 36, 37-р хуудаснаас малын төрөл тус бүр дээр үзэж болно.

1994 онд тоологдсон нийт үхрийн 4.4 хувь, хонины 4.2 хувь, ямааны 2.9 хувийг цэвэр, эрлийз мал эзлэж байна. Нийт цэвэр, эрлийз малын 34.8 нь хөдөө аж ахуйн компани, хоршоо, улсын үйлдвэрийн газарт, 59.2 хувь нь хувийн аж ахуйд байна.

1994 оны эцэст цэвэр үүлдрийн болон эрлийз 476.0 мянган хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 38.7 мянгаар цөөрчээ. Цэвэр үүлдрийн болон эрлийз малын сүрэгт үнээ 49.2 хувь, эм хонь 51.9 хувь, эм ямаа 52.5 хувийг эзлэж байна.

Нутгийн шилдэг омгийн үхэр 25.5, хонь 770.0, ямаа 50.6 мянга тоологдсон нь 1993 оныхоос үхэр 8.0, хонь 2.0, ямаа 11.4 мянгаар өслөө.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн  
малын өсөлт, төрлөөр ( мян.тол )

	1993	1994	1994\1993	
			хувь	зөрүү
<b>1.Цэвэр үүлдрийн бүх мал</b>	<b>334.8</b>	<b>338.6</b>	<b>101.1</b>	<b>3.8</b>
үхэр	46.2	39.3	85.1	-6.9
хонь	221.8	226.6	102.2	4.8
ямаа	66.8	72.7	108.8	5.9
<b>2. Эрлийз</b>	<b>666.6</b>	<b>583.0</b>	<b>87.5</b>	<b>-83.6</b>
үхэр	100.3	94.4	94.1	-5.9
хонь	424.9	348.9	82.1	-76.0
ямаа	141.4	139.7	98.8	-1.7
<b>3.Нутгийн шилдэг омгийн</b>	<b>824.7</b>	<b>846.1</b>	<b>100.8</b>	<b>21.4</b>
үхэр	17.5	25.5	145.7	8.0
хонь	768.0	770.0	100.3	2.0
ямаа	39.2	50.6	129.1	11.4

Цэвэр үүлдэр, эрлийз малын тоо, аж ахуйн салбараар. ( мян.тол )

	Нийт цэвэр эрлийз мал		Үхэр		Хонь		Ямаа	
	1993	1994	1993	1994	1993	1994	1993	1994
ХАА-н компани,УҮГ	418.6	320.6	61.7	43.3	313.7	257.5	43.2	19.8
Хувийн аж ахуй	525.6	545.6	80.6	86.7	299.3	285.9	145.7	173.0
Бусад	57.2	55.3	4.2	3.7	33.7	32.1	19.3	19.5
ДҮН	1001.4	921.5	146.5	133.7	646.7	575.5	208.2	212.3
Салбаруудын эзлэх хувийн жин								



ХАА-н компани,УУГ	41.8	34.8	42.2	32.4	48.5	44.7	20.7	9.3
Хувийн аж ахуй	52.5	59.2	55.0	64.8	46.3	49.7	70.0	81.5
Бусад	5.7	6.0	2.9	2.8	5.2	5.6	9.3	9.2
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Нийт малд цэвэр үүлдрийн болон эрлийз малын эзлэх хувь

	Үхэр		Хонь		Ямаа	
	1993	1994	1993	1994	1993	1994
Бүгд	5.4	4.4	4.7	4.2	3.4	2.9
-Цэвэр	1.7	1.3	1.6	1.6	1.0	1.0
-Эрлийз	3.7	3.1	3.1	2.5	2.3	1.9
Үүнээс:ХАА-н компани	40.6	36.3	27.8	30.6	28.6	16.1
-Цэвэр	24.0	24.0	13.4	18.3	4.6	0.9
-Эрлийз	16.5	12.4	14.4	12.3	24.0	15.2
Хувийн аж ахуй	3.2	3.0	2.5	2.4	2.5	2.5
-Цэвэр	0.3	0.3	0.6	0.6	0.7	0.7
-Эрлийз	2.9	2.7	1.9	1.8	1.8	1.8

Цэвэр үүлдрийн болон эрлийз хээлтэгч малын тоо ( мян.тол )

	1993	1994	1994\1993	
			Хувь	Зөрүү
1.Цэвэр үүлдрийн хээлтэгч	180.9	178.4	98.6	-2.5
Үнээ	22.1	20.7	93.7	-1.4
Эм хонь	122.4	118.8	97.1	-3.6
Эм ямаа	36.4	38.9	106.9	2.5
2.Эрлийз үүлдрийн	333.8	297.6	89.2	-36.2
Үнээ	39.6	45.1	113.9	5.5
Эм хонь	225.1	179.8	79.9	-45.3
Эм ямаа	69.1	72.7	105.2	3.6

Цэвэр үүлдрийн болон эрлийз малын хээлтэгчийн эзлэх хувь

	Үнээ		Эм хонь		Эм ямаа	
	1993	1994	1993	1994	1993	1994
Бүгд	42.1	49.2	53.7	51.9	50.9	52.5
-Цэвэр	47.8	52.8	55.1	52.5	54.4	53.5
-Эрлийз	39.5	47.8	53.0	51.5	49.0	52.0
Үүнээс:ХАА-н компани	47.3	54.0	58.7	55.8	43.6	47.7
-Цэвэр	49.6	55.9	60.0	56.4	48.1	48.6
-Эрлийз	46.0	50.5	57.6	54.9	42.6	47.7
Хувийн аж ахуй	37.2	47.0	50.0	48.5	51.9	51.7
-Цэвэр	39.5	44.2	44.2	43.9	52.0	49.4
-Эрлийз	37.0	47.4	50.0	50.0	50.9	52.6

### III. Малын хашаа, уст цэг

**III. Малын хашаа, худаг.** 1994 оны эцэст улсын хэмжээгээр 27.1 сая толгой малын багтаамжтай 84.1 мянган хашаа тоологдсон нь ноднин жилийнхээс хашааны тоо 8.0 мянга, багтаамж нь 1.0 сая толгойгоор нэмэгджээ.

Богийн 25.0 сая толгой малын багтаамжтай 65.6 мянган хашаа байгаагийн 3.3 хувь нь дулаан байр, 11.4 хувь нь дулаалгатай хашаа, 66.2 хувь нь саравчтай хашаа, 19.1 хувь нь саравчгүй хашаа байна. Эдгээр хашааны 70.3 хувь нь өвөлжөөнд байгаа бөгөөд 90.0 хувь нь хувийн, 10.0 хувь нь хөдөө аж ахуйн компани, хоршоо, улсын үйлдвэрийн газрын мэдэлд байна.

1994 онд 1170.2 мянган толгой малын багтаамжтай 7848 хашаа шинээр ашиглалтанд оруулсан нь ноднин жилийнхээс 1660 хашаагаар нэмэгджээ.

Баянхонгор, Завхан, Хэнтий, Дорнод, Баян-Өлгий аймагт малын хашааны багтаамж ноднин жилийнхээс 55.9-455.4 мянган малынхаар буурсан байна.

1994 оны тооллогоор бүртгэгдсэн нийт хашаанаас 7.1 сая төгрөгийн үнэ бүхий 428 хашаа ашиглагдахгүй байгаагийн 83.4 хувь нь Хөвсгөл, Өмнөговь, Төв, Ховд, Говь-Алтай, Сэлэнгэ, Баян-Өлгий аймагт ногдож байна.

#### Малын хашааны тоо, багтаамж

	1986-1990 оны дундаж	1991	1992	1993	1994	1994\1993 хувь
Хашаа бүгд(мян)	67.8	68.0	74.4	76.1	84.1	110.5
Багтаамж (сая.тол)	31.4	28.3	27.7	26.1	27.1	103.8
Шинээр барьсан хашааны тоо	2015	1466	4993	6188	7848	126.8
Багтаамж (сая.тол)	0.9	0.5	1.0	1.9	1.2	63.2
Хашаажилтын хувь –бод	105.6	80.8	65.4	65.6	61.8	94.2
--бог	154.7	130.1	127.8	120.6	118.8	98.5

1994 оны байдлаар бог мал 1.2 ээлжийн хашаагаар, үхрийн 61.8 хувь нь нэг ээлжийн хашаагаар хангагдсан байна.

Сэлэнгэ, Завхан, Сүхбаатар, Увс, Баянхонгор, Төв аймагт үхэр, бог малын хашааны хангамж бусад аймгаас харьцангуй доогуур байна. ( Хавсралт хуудасны дугаар 41 – 44 )

**Уст цэг.** Улсын хэмжээгээр 1986-1990 онд дунджаар 41.9 мянган худагтай байсан бол 1994 оны эцэст 35.6 мянган худаг тоологджээ. 1994 онд шинээр 909 худаг ашиглалтанд оруулсны 896 нь энгийн уурхайн худаг байна.

1993 оныхоос өрөмдөл худаг 800, богино яндант 654, бетон хашлагатай 226-аар буурч, энгийн уурхайн худаг 918-аар нэмэгджээ.

Нийт худгийн тоо 12 аймагт 1993 оныхоос буурсны дотор Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Говь-Алтай, Ховд, Өмнөговь, Баянхонгор аймагт 112 – 301, Булган, Архангай, Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай аймагт 30 – 98 худгаар багасчээ.

( Хавсралт хүснэгт 45, 46 )

Уст цэгийн тоо ( мян.ш )

	1986-1990 дундаж	1991	1992	1993	1994	1994\1993 хувь
Худаг бүгд	41.9	37.6	36.3	36.3	35.6	97.9
Үүнээс: Өрөмдмөл	7.4	6.6	6.2	5.6	4.8	85.7
Богино яндант	7.6	7.2	6.8	6.5	5.8	89.9
Бетон хашлагат	10.0	8.5	7.7	7.1	6.9	96.8
Энгийн уурхайн	16.9	15.3	15.6	17.1	18.1	105.4
Мал услах сан	4.2	3.6	2.9	2.6	2.2	85.1

Улсын хэмжээгээр 1994 онд 31.7 мянган м.куб багтаамжтай 2189 мал услах сан тоологдсон нь ноднин жилийнхээс 383-аар буурсан байна. 31.1 мянган га талбай услах хүчин чадалтай 100 услалтын систем байгаагаас 54.8 сая төгрөгийн үнэтэй 9.0 мянган га талбай услах чадалтай 34 услалтын систем ашиглагдахгүй байна.( Хавсралт хуудасны дугаар 46 )

1994 онд 233.7 сая төгрөгийн үнэтэй 5237 худаг ашиглагдахгүй байгаа нь ноднин жилийнхээс 22.0 хувиар их байна.

Ашиглалтгүй худгийг аймгаар үзүүлбэл:

Ашиглалтгүй байгаа худгийн тоо	А Й М А Г
95 – 190	Баян-Өлгий, Увс, Сэлэнгэ, Булган, Ховд
232 – 287	Сүхбаатар, Баянхонгор, Завхан, Дундговь, Говь-Алтай, Дорноговь
317 – 480	Төв, Дорнод, Хөвсгөл, Хэнтий, Өмнөговь, Архангай, Өвөрхангай

### III.2. Малын тэжээлийн үйлдвэрлэлт

**Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж.** 1994 онд улсын хэмжээгээр 373.2 мянган тонн тэжээлийн нэгжтэй тэнцэх хэмжээний тэжээл үйлдвэрлэсэн нь 1993 оныхоос 9.2 хувь буюу 37.6 мянган тонноор буурсан байна.

Баян-Өлгий, Дорноговь, Ховд, Өвөрхангай, Хэнтий, Архангай тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ ( тэжээлийн нэгжид шилжүүлснээр ) өнгөрсөн оныхоос 0.4 - 9.4 мянган тонноор нэмэгджээ.

Үйлдвэрлэсэн тэжээлийг нэр төрлөөр нь авч үзвэл бэлтгэсэн өвс, гар ба эрдэс тэжээлийн хэмжээ өмнөх оныхоос нэмэгдэж, багсармал тэжээл, бэлтгэсэн

дарш, сүрэл, нэг наст өвс, олон наст өвсний хэмжээ 8.4 – 77.5 хувиар багассан байна.

1994 оны байдлаар хонин толгойд шилжүүлсэн нэг малд тэжээлийн нэгжээр 6.5 кг тэжээл ногдож байгаа нь 1993 оныхоос 1.3 кг-аар багассан бөгөөд энэ нь нийт малыг 3.2 хоног тэжээх нөөц юм.

1994 онд улсын хэмжээгээр 691.8 мянган тонн байгалийн хадлан бэлтгэсэн нь өнгөрсөн оныхоос 2.0 мянган тонноор буюу 0.3 хувь нэмэгдэв. Харин Говьсүмбэр, Сүхбаатар, Баянхонгор, Сэлэнгэ, Говь-Алтай, Дорнод, Булган, Дархан-Уул, Орхон, Архангай аймаг, Улаанбаатар хотод бэлтгэсэн өвсний хэмжээ 1993 оныхоос 0.2-59.1 хувиар буурсан байна. ( Хавсралт 47 – 50 )

Улсын фондод 728.4 мян.тонн өвс бэлтгэжээ.

Тэжээлийн хэмжээг нэр төрлөөр үзүүлбэл : ( мян.т )

	1991	1992	1993	1994	1994\1993 хувь
Байгалийн хадлан үүнээс	878.6	668.8	689.7	691.8	100.3
----- Улсын фондын өвс	157.6	77.5	39.8	0.7	1.8
Сүрэл	54.6	31.9	26.7	22.3	83.3
Нэг наст өвс	65.9	25.0	18.0	4.0	22.5
Олон наст өвс	8.2	8.3	4.7	1.4	30.0
Гар тэжээл (тэж.нэгж)	10.1	6.6	7.6	11.6	151.8
Багсармал тэжээл	23.6	21.0	15.1	13.8	91.6
Бэлтгэсэн дарш	91.1	128.7	64.4	30.5	47.5
Эрдэс тэжээл	15.5	12.9	16.8	18.9	112.4
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд(тэж.нэгж)	564.4	403.7	410.9	373.3	90.8

Тэжээлийн бүтцийг авч үзвэл хүчит болон шүүст тэжээлийн хэмжээ 1993 оныхоос буурч, бүдүүн тэжээлийн хэмжээ нэмэгдэв.

Үйлдвэрлэсэн тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж ( хувиар )

	1991	1992	1993	1994
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
хүчит	15.2	11.5	15.3	9.5
шүүст	5.3	7.1	3.9	2.2
бүдүүн	77.6	81.4	80.8	88.3
Бусад	1.9	-	-	-

#### IV. Тэжээвэр амьтад.

1994 оны эцэст 23.4 мянган гахай, 74.1 мянган шувуу, туулай 129, үнэг 215, булга 2696 тоологдов. Урьд оныхоос гахайн тоо 5.2 мянга, шувууны тоо 57.5 мянгаар буурчээ. 1990 оныхоос гахайн тоо 5.8 дахин, шувууны тоо 4.4 дахин цөөрлөө.

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөж, үржүүлдэг өрх, аж ахуйн тоо

	1990	1991	1992	1993	1994	1994\1993
Гахай (мян.тол)	134.7	83.3	48.6	28.6	23.4	81.7
Шувуу (мян.тол)	326.2	223.3	184.0	131.6	74.1	56.3
Цаа буга	1171	1336	1427	1415	1170	82.7
Илжиг, луус	1018	791	935	874	993	113.6
Зөгий ( бүл )	4768	4567	1473	1237	1386	112.0
Туулай	7179	2047	164	142	129	90.8
Үнэг	1251	1209	1001	1060	215	20.3
Булга	9691	7513	6005	4571	2696	59.0
Гахайтай өрхийн тоо (мян)	15.7	12.1	7.6	5.4	4.1	76.6
Шувуутай өрхийн тоо	1271	1336	1569	1813	1792	98.8
Гахай өсгөж үржүүлдэг АА, байгууллагын тоо	845	482	225	148	97	65.5
Шувуу өсгөж үржүүлдэг АА, байгууллагын тоо	150	56	37	33	22	66.7

Гахайн тоо Сүхбаатар, Хэнтийгээс бусад бүх аймаг, хотод, шувууны тоо Увс, Хэнтий, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Архангай, Говь-Алтай, Дорнод, Булганаас бусад бүх аймаг, хотод буурсан байна. Үүний дотор нийслэлийн шувууны фабрикийн шувууны тоо 45.3 хувь буюу 58.2 мянгаар хорогджээ. ( Хавсралт хүснэгт 38-40 )

1994 онд аминдаа гахайтай өрх 4.1 мянга, шувуутай өрх 1.8 мянга болсон нь 1993 оныхоос гахайтай өрх 1.3 мянга, шувуутай өрх 21-ээр цөөрчээ. 10 аймаг, Улаанбаатар хотод шувуутай өрхийн тоо нэмэгдсэн байна.

Одоо нийт гахайны 85.6 хувь, шувууны 30.3 хувь хувийн аж ахуйд байна.

Гахай, шувууны тоо, өмчийн төрлөөр ( мян.тол )

	Гахай				Үндсэн мэгж			Хувийн жин
	1993	1994	1994\1993 хувь	Хувийн жин	1993	1994	1994\1993 хувь	
Дүн	28.6	23.4	81.7	100.0	6738	5542	82.2	100.0
ХАА-н компани, хоршоо, УҮГ	1.9	1.9	100.0	8.1	619	415	67.0	7.5
Үүнээс: хувийн аж ахуй	24.8	20.0	80.8	85.6	5724	4881	85.3	88.1
Бусад	1.9	1.5	75.6	6.3	395	246	62.3	4.4

үргэлжлэл

	Ш у в у у				Өндөглөгч			
	1993	1994	1994\1993 хувь	Хувийн жин	1993	1994	1994\1993 хувь	Хувийн жин
Дүн	131.5	74.1	56.3	100.0	81.2	33.8	41.6	100.0
ХАА-н компани, хоршоо, УҮГ	110.4	50.8	46.0	68.6	67.3	18.3	27.2	54.0
Үүнээс: хувийн аж ахуй	18.8	22.5	119.1	30.3	12.0	15.0	124.7	44.4
Бусад	2.3	0.8	34.6	1.1	1.9	0.5	26.6	1.6

## ДҮГНЭЛТ

Манай орны малчдын 54 хувь нь залуучууд болсон өнөөгийн нөхцөлд нийт малчин өрхийн 11.8 хувь цахилгаан гэрэлтэй, 6.5 хувь телевизортой, өрхийн гуравны нэг нь радио сонсох боломжгүй байгаа нь тэдгээрийн ахуйн соёл, мэдээлэлийн хэрэгцээ шаардлагаас их хоцорч байна. Иймд малчдын төрөл бүрийн цахилгааны эх үүсвэрээр хангах, малчдад зориулан хуурай зай тэжээл бүхий радио хүлээн авагч, телевизорыг дотооддоо угсрах ажлыг өргөжүүлэхэд мэдэгдэхүйц ахиц гаргах шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд экспортонд гаргах мал, махны хэмжээ эрс буурсан нь малын тоо толгой өсөхөд бодитой нөлөөлөв. Зөвхөн 1994 онд 1987 – 1989 оны дунджаар экспортод гаргасан малын тоотой тэнцэх хэмжээний малыг экспортлосон бол 24.7 сая малтай байх тооцоо гарч байна. Үүнээс үзвэл мал өсгөх нөөц бололцоо бас төдийлөн сайн дайчлагдсангүй. 1994 онд 1986 – 1990 оны дунджаас 100 эхээс бойжуулсан төл 3-аар доогуур, малын хээл хаялт, сувайралт 167.0 мянгаар их байна.

Хөдөө орон нутагт малчид бэлэн мөнгөгүйгээс хонь төлбөрийн хэрэгсэл боллоо. Энэ байдлаас шалтгаалан сүүлийн хоёр жилд хонины тоо толгойн өсөлт зогсонги болж, 13.8 саяаас хэтрэхгүй байна. Иймд хониор өргөн хэрэгцээний бараа худалдан авдаг эдийн засгийн нөхцөл бий болсныг өөрчилж, мал аж ахуйн түүхий эдийг худалдан авах мөнгөний урсгалыг хөдөөд чиглүүлэх механизм бүрдүүлэх шаардлагатай байна.

Ямаан сүргийн тоо 1993 оныхоос 1.1 сая толгойгоор нэмэгдсэн нь нийт малын тоо 1.6 саяаар өсөхөд шийдвэрлэх нөлөө үзүүлэв. Сүрэгт ямааны эзлэх хувийн жин эрс нэмэгдэж, 1990 онд 19.8 хувь байсан бол 1994 онд 27.0 хувь болсон байна. Бог малын дотор хонь, ямаа 3:1 гэсэн харьцаатай байсан бол одоо 2:1 гэсэн харьцаатай боллоо. Зөвхөн ноолуурт баригдан ямааг хэт өсгөх нь сүргийн бүтцийн тэнцвэр алдагдуулж, махны үйлдвэрлэлт, хангамжинд зохисгүй нөлөөлөх үр дагаварт хүрч болох юм. Ямааг хүнсэнд хэрэглэх нь эрс багаслаа.

Цаашдаа манай орны таван төрлийн малд ямааг ямар байр суурь эзлүүлэн өсгөх нь зохистой вэ гэдэг асуудал гарч ирж байна. Ямааг өсгөж үржүүлж ирсэн уламжлалт харьцааг баримтлах нь зүйтэй болов уу.

Гахай, шувуу, үнэг, булга зэрэг тэжээвэр амьтадын тоо үлэмжхэн хорогджээ. Улаанбаатарын шувууны тоо 2 дахин, үслэг ангийн аж ахуйн үнэгний тоо 4.9 дахин, булганы тоо 1.7 дахин буурсан байна. Гахай, шувуу өсгөж үржүүлэх боломжоор харьцангуй сайн Төв, Сэлэнгэ, Хөвсгөл, Өвөрхангай, Орхон аймаг, нийслэл хотод тоо толгой нь хорогдсоор байгааг анхаарах цаг болсон байна.

Хадлан, тэжээл бэлтгэх хэмжээ сүүлийн жилүүдэд их буурав. Цаг агаарын тааламжтай байдал үргэлж тохиолдохгүй нь мэдээж тул хувийн аж ахуйтнуудыг хүрэлцээтэй хадлан өвс, гар тэжээл бэлтгэн авахуулахад идэвхижүүлэх талаар аймаг, сумдын удирдлагаас үр нөлөөтэй ажил өрнүүлэх хэрэгтэй болж байна.

## ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН

ГАЗРЫН ДЭД ДАРГА.....Б.БАТМӨНХ